

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/207/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН УНАГАЛДАЙН АНДУУД
ЦЭЦЭРЛЭГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

| | |
|---|----|
| Товчилсон үгийн жагсаалт | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 8 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 11 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 12 |
| 3. Аудитын тайлан..... | 13 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 13 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 13 |
| 3.4 Материаллаг байдал..... | 14 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 14 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 15 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 16 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 16 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 16 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 16 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 17 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 17 |
| 4. Аудитын илрүүлэлт | 18 |
| 4.1 Залруулсан алдаа..... | 18 |
| 4.2 Төлбөрийн акт | 18 |
| 4.3 Албан шаардлага..... | 18 |
| 4.4 Зөвлөмж..... | 18 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТБОНӨ | Төрийн болон орон нутгийн өмч |
| ТББ | Төрийн бус байгууллага |



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/91
танай -ны № -Т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020314

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 36,410,943.00 | 41,515,208.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 36,410,943.00 | 41,515,208.00 |
| 354 | Хангамжийн материал | 36,410,943.00 | 41,515,208.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,532,560.00 | 4,274,025.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 33,878,383.00 | 37,241,183.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,104,806,981.82 | 1,075,473,275.13 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,104,806,981.82 | 1,075,473,275.13 |
| 392 | Биет хөрөнгө | 977,786,981.58 | 948,457,858.22 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,034,595,394.00 | 1,034,595,394.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -97,509,183.56 | -122,232,184.16 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 40,888,879.00 | 44,436,277.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -18,409,694.83 | -23,012,803.91 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,001,097.51 | 38,601,097.51 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -19,779,510.54 | -23,929,922.22 |
| 393 | Биет бус хөрөнгө | 127,020,000.24 | 127,015,416.91 |
| 39301 | Программ хангамж | 440,000.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -329,999.76 | -334,583.09 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 126,910,000.00 | 126,910,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,141,217,924.82 | 1,116,988,483.13 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,141,217,924.82 | 1,116,988,483.13 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,141,217,924.82 | 1,116,988,483.13 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 126,910,000.00 | 126,910,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 126,910,000.00 | 126,910,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,014,307,924.82 | 990,078,483.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,014,307,924.82 | 1,014,307,924.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -24,229,441.69 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,141,217,924.82 | 1,116,988,483.13 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| | | | /төгрөгөөр/ | |
|-------------|--|-----------------------|-----------------------|--|
| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 580,601,400.00 | 578,115,450.00 | |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,226,700.00 | 3,112,150.00 | |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 360,000.00 | 00.00 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 360,000.00 | 00.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 360,000.00 | 00.00 | |
| 122 | Тусламжийн орлого | 9,866,700.00 | 3,112,150.00 | |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 9,866,700.00 | 3,112,150.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 88,802,200.00 | 119,849,700.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 481,572,500.00 | 455,153,600.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 9,097,400.00 | 40,144,900.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,097,400.00 | 40,144,900.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 79,704,800.00 | 79,704,800.00 | |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,704,800.00 | 79,704,800.00 | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 600,211,529.07 | 602,344,891.69 | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 600,211,529.07 | 602,344,891.69 | |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 451,047,352.84 | 487,241,157.06 | |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 277,035,164.05 | 321,625,098.00 | |
| 210101 | Үндсэн цалин | 212,918,537.16 | 255,306,819.92 | |
| 210102 | Нэмэгдэл | 49,613,934.81 | 66,318,278.08 | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 968,000.00 | 00.00 | |
| 210104 | Урамшуулал | 13,534,692.08 | 00.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,069,935.72 | 42,266,282.37 | |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,758,987.72 | 37,413,501.37 | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,421,317.00 | 1,277,890.00 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,937,053.00 | 1,022,313.00 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 443,815.00 | 229,325.00 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,508,763.00 | 2,323,253.00 | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 69,315,288.00 | 71,685,915.00 | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,030,168.00 | 2,056,905.00 | |
| 210302 | Түлш, халаалт | 62,599,680.00 | 62,514,188.00 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,685,440.00 | 7,114,822.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,421,200.00 | 1,110,857.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | 283,800.00 | 168,150.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,000.00 | 150,000.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200,000.00 | 146,000.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 90,000.00 | 00.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 320,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,787,400.00 | 326,707.00 | |
| 2105 | Нормативт зардал | 29,626,040.00 | 12,419,500.00 | |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,000.00 | 18,000.00 | |

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210502 | Хоол, хүнс | 29,030,540.00 | 11,221,650.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 550,500.00 | 1,179,850.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 488,470.00 | 2,620,440.00 |
| 210604 | Урсгал засвар | 488,470.00 | 2,620,440.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 00.00 | 80,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 80,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 504,000.00 | 00.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 504,000.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,587,255.07 | 35,433,064.69 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,659,240.00 | 1,476,720.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 330,300.00 | 475,240.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,597,715.07 | 33,481,104.69 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 149,164,176.23 | 115,103,734.63 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,097,400.00 | 39,844,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 17,873,100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,097,400.00 | 21,971,800.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 135,948,400.23 | 69,859,949.63 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 135,948,400.23 | 69,859,949.63 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,118,376.00 | 5,398,885.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,118,376.00 | 5,398,885.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -19,610,129.07 | -24,229,441.69 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -19,610,129.07 | -24,229,441.69 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | /төгрөгөөр/ |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------------|--|
| | | | | | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 126,910,000.00 | 00.00 | 1,033,918,053.89 | 1,160,828,053.89 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 126,910,000.00 | 00.00 | 1,033,918,053.89 | 1,160,828,053.89 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -19,610,129.07 | -19,610,129.07 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 126,910,000.00 | 00.00 | 1,014,307,924.82 | 1,141,217,924.82 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 126,910,000.00 | 00.00 | 1,014,307,924.82 | 1,141,217,924.82 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 126,910,000.00 | 00.00 | 1,014,307,924.82 | 1,141,217,924.82 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -24,229,441.69 | -24,229,441.69 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 126,910,000.00 | 00.00 | 990,078,483.13 | 1,116,988,483.13 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 572,214,400.00 | 577,065,985.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,839,700.00 | 2,062,685.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,839,700.00 | 2,062,685.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,839,700.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,839,700.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 2,062,685.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 570,374,700.00 | 575,003,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 481,572,500.00 | 455,153,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 9,097,400.00 | 40,144,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,097,400.00 | 40,144,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 79,704,800.00 | 79,704,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,704,800.00 | 79,704,800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 571,314,600.00 | 574,666,587.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 571,314,600.00 | 574,666,587.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 422,150,423.77 | 459,562,852.37 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 273,158,002.03 | 321,675,606.26 |
| 210101 | Үндсэн цалин | 209,041,375.14 | 255,357,328.18 |
| 210102 | Нэмэгдэл | 49,613,934.81 | 66,318,278.08 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 968,000.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 13,534,692.08 | 00.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 37,587,097.74 | 42,215,774.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,882,695.39 | 30,484,141.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,048,932.81 | 3,083,826.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 841,989.74 | 2,443,541.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 193,579.51 | 557,841.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,619,900.29 | 5,646,422.88 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,097,954.00 | 71,685,915.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,030,168.00 | 12,409,245.00 |
| 210302 | Түлш, халаалт | 69,450,446.00 | 56,162,240.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,617,340.00 | 3,114,430.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,331,200.00 | 2,508,950.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 193,800.00 | 144,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,000.00 | 150,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200,000.00 | 201,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 90,000.00 | 33,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 320,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,787,400.00 | 1,660,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 31,817,400.00 | 16,114,364.00 |

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|---------------------------|-----------------------------|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,000.00 | 44,707.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,215,200.00 | 15,025,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 557,200.00 | 1,043,857.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 488,470.00 | 2,620,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 488,470.00 | 2,620,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 00.00 | 80,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 80,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 504,000.00 | 00.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 504,000.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,166,300.00 | 2,662,243.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 836,000.00 | 2,080,503.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 330,300.00 | 581,740.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 149,164,176.23 | 115,103,734.63 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,097,400.00 | 39,844,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 17,873,100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,097,400.00 | 21,971,800.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 135,948,400.23 | 69,859,949.63 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 135,948,400.23 | 69,859,949.63 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,118,376.00 | 5,398,885.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,118,376.00 | 5,398,885.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>899,800.00</u> | <u>2,399,398.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | <u>899,800.00</u> | <u>2,399,398.00</u> |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | <u>899,800.00</u> | <u>2,399,398.00</u> |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 899,800.00 | 2,399,398.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 899,800.00 | 2,399,398.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-899,800.00</u> | <u>-2,399,398.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | /төгрөгөөр/ | |
|-----------------------|---|-----------------------|---------------|----------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 534,858,400.0 | 461,662,250.4 | 73,196,149.6 | 86.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 534,858,400.0 | 461,662,250.4 | 73,196,149.6 | 86.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 534,858,400.0 | 461,662,250.4 | 73,196,149.6 | 86.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 355,585,100.0 | 321,675,606.3 | 33,909,493.7 | 90.5 |
| 210101 | Үндсэн цалин | 234,387,200.0 | 255,357,328.2 | (20,970,128.2) | 108.9 |
| 210102 | Нэмэгдэл | 68,499,900.0 | 66,318,278.1 | 2,181,621.9 | 96.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,640,000.0 | - | 13,640,000.0 | - |
| 210104 | Урамшуулал | 39,058,000.0 | - | 39,058,000.0 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,003,900.0 | 42,215,774.1 | 5,788,125.9 | 87.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,780,600.0 | 30,484,141.9 | 3,296,458.1 | 90.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,555,800.0 | 3,083,826.4 | 471,973.6 | 86.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,844,700.0 | 2,443,541.0 | 401,159.0 | 85.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 711,100.0 | 557,841.9 | 153,258.1 | 78.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,111,700.0 | 5,646,422.9 | 1,465,277.1 | 79.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 77,084,800.0 | 71,685,915.0 | 5,398,885.0 | 93.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,520,000.0 | 12,409,245.0 | (1,889,245.0) | 118.0 |
| 210302 | Түлш, халаалт | 59,085,900.0 | 56,162,240.0 | 2,923,660.0 | 95.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,478,900.0 | 3,114,430.0 | 4,364,470.0 | 41.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,441,600.0 | 3,068,750.0 | 372,850.0 | 89.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 200,000.0 | 144,750.0 | 55,250.0 | 72.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 150,000.0 | 150,000.0 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 280,000.0 | 201,000.0 | 79,000.0 | 71.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 91,600.0 | 33,000.0 | 58,600.0 | 36.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.0 | 320,000.0 | 180,000.0 | 64.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,220,000.0 | 2,220,000.0 | - | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 43,582,000.0 | 16,114,364.0 | 27,467,636.0 | 37.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,000.0 | 44,707.0 | 293.0 | 99.3 |
| 210502 | Хоол, хүнс | 41,787,000.0 | 15,025,800.0 | 26,761,200.0 | 36.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,750,000.0 | 1,043,857.0 | 706,143.0 | 59.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,620,000.0 | 2,620,000.0 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,620,000.0 | 2,620,000.0 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 100,000.0 | 80,000.0 | 20,000.0 | 80.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 100,000.0 | 80,000.0 | 20,000.0 | 80.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,441,000.0 | 4,201,841.0 | 239,159.0 | 94.6 |

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|--|---------------|---------------|-----------|-------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,793,000.0 | 2,700,301.0 | 92,699.0 | 96.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,648,000.0 | 1,501,540.0 | 146,460.0 | 91.1 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 534,858,400.0 | 534,858,400.0 | - | 100.0 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 455,153,600.0 | 455,153,600.0 | - | 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 455,153,600.0 | 455,153,600.0 | - | 100.0 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 79,704,800.0 | 79,704,800.0 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 79,704,800.0 | 79,704,800.0 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 17.0 | 17.0 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8.0 | 8.0 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.0 | 8.0 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| /төгрөгөөр/ | | | |
|-------------|--|----------------------|----------------------|
| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 40,144,900.00 | 40,144,900.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 40,144,900.00 | 40,144,900.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 300,000.00 | 300,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 300,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 300,000.00 | 300,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39844900.00 | 39844900.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 39,844,900.00 | 39,844,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,873,100.00 | 17,873,100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 21,971,800.00 | 21,971,800.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 40144900.00 | 40144900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 40,144,900.00 | 40,144,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 40,144,900.00 | 40,144,900.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Жишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэг нь орон нутгийн болон бага насны хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээг тусгасан сургалтын хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэн, хүүхэд нэг бүрийг бүтээлээр хөгжих, төлөвших боломжийг бий болгохыг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрхлэгчийн тушаалаар томилогдсон дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг нь байгууллагын гадаад, дотоод орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, “Эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-ний дагуу хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан, 5 удаагийн шалгалт хийж, 5 төрлийн зөрчлийг илрүүлэн, арилгуулсан.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба

хэрэгжүүлдэг. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 534,858.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,022.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,017.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 534,858.4 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 40,144.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 574,666.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 3,547.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 600.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 4,147.4 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,399.4 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,748.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 1,175.6 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 22,287.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 18,358.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дангүй байна. Бараа материал 41,515.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,075,473.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---------------------|---------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 36,410.94 | 41,515.21 | 5,104.27 |
| Үндсэн хөрөнгө | 1,104,806.98 | 1,075,473.27 | (29,333.71) |
| Нийт хөрөнгө | 1,141,217.92 | 1,116,988.48 | (24,229.44) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,141,217.92 | 1,116,988.48 | (24,229.44) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,141,217.92 | 1,116,988.48 | (24,229.44) |

Бараа материалын дансны үлдэгдэл 41,515.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 5,104.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,075,473.3 мянган төгрөг болж 29,333.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,116,988.5 мянган төгрөг болж 24,229.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 534,858.4 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 534,858.4 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 534,858.4 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 534,858.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 461,662.3 мянган төгрөгийг

батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 73,196.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 461,662.3 мянган төгрөг буюу 86.3 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 40,144.9 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 300.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 17,873.1 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 21,971.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд хичээлийн Б байранд 2 бүлэг шинээр нэмэгдэж, тус бүлгүүдэд Төв нутгийн залуус ТББ-аас 1,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр хивсэн дроз, тоглоомын тавиур авч тохижуулсан, А байрны засварын ажилд Хорго групп ХХК-аас 200.0 мянган төгрөгийн үнэ бүхий барилгын материалаар туслалцаа үзүүлсэн, цэцэрлэгийн зөвлөлөөс “Миний оролцоо” сэдэвт ажлыг зохион байгуулж, 4 төсөл хэрэгжүүлж 5,200.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 21 нэр төрлийн 11,466.1 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 10 нэр төрлийн 3,236.5 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 92 мэдээллийг хугацаандаа, 26 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг мэдээлээгүй, цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 2 удаагийн нийт 13,678.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 92 мэдээллийг хугацаандаа, 26 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг мэдээлээгүй, цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 2 удаагийн нийт 13,678.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг тус тус мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 254.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2,491.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил нь давтан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28,381.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28,381.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 21 нэр төрлийн 11,466.1 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 10 нэр төрлийн 3,236.5 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 92 мэдээллийг хугацаандаа, 26 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг мэдээлээгүй, цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 2 удаагийн нийт 13,678.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д / Д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|-------|--|-------------------|----------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэг | 3 | 28,381.0 | - | - | - | - | - | - | 3 | 28,381.0 |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn